



ШУТИС-ИЙН ОЮУТНЫ III БАЙР

ШУТИС-ийн Оюутны 3-р байрны Танилцуулга

ШУТИС-н Оюутны III байр нь анх 1984 онд ашиглалтанд орсон бөгөөд 400 гаруй оюутан амьдрах хүчин чадалтай дөрвөн давхар барилга юм. КТМС, ЭХИС, УУИС-ийн оюутнууд амьдардаг. Өрөөнүүд нь 2 болон 4 хүний тасагтай. Өрөө бүртээ угаалгын болон ариун цэврийн өрөөтэй. 2011 оноос нийтийн гал тогооны өрөөг ашиглалтанд оруулсан. Байрны 1,2,3 давхарт оюутнууд, 4 давхарт залуу багш, орон нутгийн сургуулиас урлаг, спортын тэмцээнд оролцох оюутанг байрлуулах болон магистр, докторантурт суралцагчид амьдардаг. 2010 оны Улсын “Оны Тэргүүний Байр”. 2011,2012 оны ШУТИС-ийн “Шилдэг Байр” тус тус болж байсан.

2 хүний өрөө



4 хүний өрөө



Байрны дотоод үйлчилгээ

- Номын сан /уншлага танхим 1,2/
- Байрны эмч
- Интернэт кафе
- Буфет
- Угаалга
- Душ
- Теннис
- Эрүүл мэндийн комисс
- Хэв журмын комисс

Номын сан



Уншлага 1



1367 номтой, монгол ном 1132, орос хэл дээр 25, бусад хэл дээр 210 номтой. Мөн уншлагын 2-р заалыг иж бүрэн тохижуулан 36 суудалтайгаар ашиглалтанд оруулсан. Энэ уншлагын танхим нь оюутныг бие даан хөгжиж суралцахад зориулсан 24 цаг нээлттэй үйлчилдэг. Уншлага 1, 2 танхим нь байрны 3 давхарт байрладаг.



Уншлага 2

Байрны эмч : Өрөөний дугаар №109

Эмнэлгийн салбар, багш, ажиллагсад, оюутны эрүүл мэнд, эмнэлгийн яаралтай болон анхан шатны тусламж үйлчилгээ, сургуулийн анги танхимийн ариун цэвэр, эрүүл ахуй, үйлчлэгч нарын ажлын гүйцэтгэлийн хяналт, сургуулийн цайны газрын эрүүл ахуйн хяналт, оюутны дотуур байрны ариун цэвэр, эрүүл ахуй.

Чийрэгжүүлэх төв. бялдаржуулах эмчилгээ, эмчилгээний бариа засал, уламжлалт эмчилгээ, эмчилгээний гоо сайхан, котейль эмчилгээ.



Эмчилгээний багаж тоног төхөөрөмж: УВЧ, Электрофорез, искра, нуруу, хөлийн массаж, инфра туяаны шарлага, мини сауна, коктейль эмчилгээ.

Интернэт



Интернэтээр үйлчлүүлэх үнийн тариф:

- 1-30 минут 150 төг
- 31-60 минут 300 төг

Теннис



Тоглох сонирхолтой оюутнууд хариуцсан өрөөнд цаг бичүүлж тоглодог. Байрны 2 давхарт байрладаг.

- 2-хүүхэд 30минут
- 4-хүүхэд 1цаг

Хувцас, хэрэглэл угаах угаалгын газар №103 өрөө



Душ, усны өрөө



Давхар бүртгээ душ, усны өрөө ажилладаг. Үнийн тариф 200 төг талонг Тухайн өдрийн жижүүрт бичүүлнэ.

- 1 давхарт- нийт эрэгтэй оюутнууд
- 2, 3 давхарт – нийт эмэгтэй оюутнууд

Нийтийн гал тогоо



Буфет

